



**ХЭНТИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

ХЭНТИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<p align="center">ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/ ,УБЕГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө.</p>							
<p align="center">Зорилт1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.</p>							
1.1	Хэлтсийн шинэ байрны агааржуулалтыг сайжруулах /үйлчилгээний заал, архив/ болон гадна талбайн тохижилт ногоон байгууламжийг бий болгох.	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	0	100	Хэлтсийн шинэ байрны агааржуулалтыг сайжруулах агаар сэлгэлтийн системийн ажлыг хийлгэхээр барилгын гүйцэтгэгч “Мандалконстракшн” ХХК-д үүрэг даалгавар өгөгдсөн. “Их Мянган Инженерчлэл” ХХК-аас агаар сэлгэлтийн зураг төсөв хийгдээд ирсэн. Үйлчилгээний танхимыг үйлчилгээний стандартын дагуу тохижуулсан. Үүнд мэдээллийн андройд цахим дэлгэцэн самбар, бүртгэгч нарын ширээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн харааны түвшинд байрлахаар намсгасан, үйлчилгээ авч буй иргэдийн суух сандал, хүлээлгийн сандал, улсын бүртгэгч нарын баримт бичиг хадгалах шүүгээ зэргийг шинээр байрлуулсан. Хэлтсийн байрны гадна талбайд 100 ш мод бут суулгаж , цэцгийн мандал хийж цэцэг үрслүүлсэн.	70

1.3	Тоон гарын үсэг олгох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах .	-	-Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь	40	60	Тайлангийн хугацаанд аймгийн хэмжээнд 7177 иргэний хүсэлтээр тоон гарын үсэг олгоод байна. Үүнээс иргэний үнэмлэхэнд 3550, мобайл апп-д 3594 тоон гарын үсэг олгосон. Тоон гарын үсэг олгож эхэлснээс хойш нийт 39767 иргэнд тоон гарын үсэг олгосон бөгөөд олговол зохих иргэдийн 73.4 хувьд нь олгосон байна. Цахим үйлчилгээ 24/7 булан ажиллуулж эхэлсэн бөгөөд улсын бүртгэлийн цахим бүртгэлийн машинаар энэ онд 521 тоон гарын үсэг олгосон.	100
1.4	Байгууллагын цахим хуудсыг тогтмол мэдээ мэдээллээр шинэчилж, нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллах. .	-	Цахим хуудаст байршуулсан мэдээ мэдээллийн тоо; Хандалтын тоо	162	200	<ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын үйл ажиллагааг цахим хаяг /www.khentii.burtgel.gov.mn/ болон пэйж хуудсанд 68 мэдээлэл нийтлэгдэн үүнээс зурган постер 109, видео бичлэг 13, текст 40 нийтлэгдэн нээлттэй ил тод байдлыг ханган ажиллаж байна. ➤ Албан хаагчид МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд шилжилт хөдөлгөөний тоон үзүүлэлт /гадаад паспортын бүртгэл болон шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоох, шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд бүртгэл хийсэн талаар гэх мэт/-ээр 81 удаа зурган постер өөрсдөө бэлтгэн байршуулсан. 	100

						Шилжилт хөдөлгөөний талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл /Aruukhan.mn/ -ээр мэдээлэл хийсэн. Khentii.mn сайтад хэлтсийн дарга Б.Төрхүү, улсын ахлах бүртгэгч Ш.Мөнхзул нар шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоосон болон өмнөх онуудын тоон мэдээллийг харьцуулсан талаар ярилцлага өгсөн. Эхний хагас жилийн байдлаар Байгууллагын цахим www.khentii.burtgel.gov.mn/ хаяг руу Хандалтын тоо 1721 байна.	
1.5	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх.		Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо	0	1	3-р улралд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.	50
1.6	Хууль тогтоомж, дүрэм, журмын төсөлд санал боловсруулж хүргүүлэх.	-	- Төсөлд хүргүүлсэн саналын тоо	15	5	<ul style="list-style-type: none"> ➤ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загварыг шинэчлэн боловсруулах төсөлд санал-3, УБЕГ-ын ХЭУБГазарт 2024.03.11-ний 1/117 албан бичгээр, ➤ Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгах санал-4, S.Enkhchimeg@burtgel.gov.mn ➤ Улсын бүртгэлийн байгууллагад Азийн хөгжлийн Банкны техникийн туслалцааны дэмжлэгтэй 	100

						хэрэгжүүлэх төслийн хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн шинэ системд тусгах санал-9, 2024.02.23 УБЕГ ХЭУБГазарт албан бичгээр, ➤ УБЕГ-ын ХЭУБГазрын 2024 онд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр албан хаагчдыг дадлагажуулах сургалтын төлөвлөгөөнд тусгах сургалтын санал-1 нийт 17 саналыг тус тус холбогдох чиглэлийн газарт хүргүүлсэн.		
1.7	Улсын зөрчлөөс сэргийлэх, бүртгэлийн тогтоомжийг соён зорилгоор бэлтгэж, түгээх	бүртгэлийн урьдчилан улсын хууль сурталчлах, гэгээрүүлэх контент	-	Сурталчилсан мэдээ мэдээлэл, сурталчилгаа, контентын тоо	0	3	“Эм юү би” интертаймент студитэй гэрээ байгуулан 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн цахим орчинд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар контентыг бэлтгэн түгээн тархахад бэлэн болоод байна.	80
Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.								
2.1.	Байгууллагын ажиллагааг бүртгэлийн иргэнд зорилгоор өдөрлөг”-ийг байгуулах,	үйл сурталчлах, үйлчилгээг ойртуулах "Нээлттэй зохион явуулын	-	Өдөрлөгт хамрагдсан иргэдийн тоо, Явуулын үйлчилгээ үзүүлсэн үйлчилгээний тоо	0 0	0 2	10 ➤ 2024.05.01-ний өдөр зохион байуулсан Хуулийн байгууллагуудын “Про Боно” нээлттэй өдөрлөгт хууль хяналтын бусад байгууллагатай хамтран өөрийн байгууллагын үйл ажиллагааг 82 иргэнд сурталчилж, бүртгэлийн үйлчилгээ, зөвлөгөө, мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан.	100

	үйлчилгээ /зөөврийн төхөөрөмжөөр/ үзүүлэх тоног						<p>➤ Бор-Өндөр сумын улсын бүртгэгч нар “Нээлттэй өдөрлөг зохион байгуулж Дархан, Баянмөнх сумдад болон Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэрийн ажилчдад зөөврийн тоног төхөөрөмжийг ашиглан иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн 25 бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, тоон гарын үсэг олгосон. Батноров, Бэрх, Баян-Овоо, Норовлин, Дадал сумдын улсын бүртгэгч нар хамтран алслагдсан Норовлин суманд “Нээлттэй өдөрлөг зохион байгуулж. зөөврийн тоног төхөөрөмжийг ашиглан явуулын үйлчилгээ / хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан / үзүүлж эд хөрөнгийн эрхийн улсын 10 бүртгэл бүртгэж өмчлөх эрхийн гэрчилгээг олгосон. Мөн улсын бүртгэгч нар туршлага солилцож, сайн туршлагыг бие биеэсээ суралцав. Нээлттэй өдөрлөгөөр нийт давхардсан тоогоор 205 иргэнд зөвлөгөө мэдээлэл хүргэсэн байна.</p>	
1.2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цогц үйлчилгээг сумдад хүргэх.	Орон нутгийн төсөв 2 сая	-Сумдад үзүүлсэн үйлчилгээний тоо,	537	0	55	Улсын бүртгэлийн хэлтэс нь ГХБХБГазартай хамтарсан баг гарч аймгийн 5 сум 1 тосгонд очиж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цогц үйлчилгээ-нээлттэй газрын харилцаа орон нутагт	100

						өдөрлөгийг зохион байгуулж гезер дээр нь өмчлөх эрхийн гэрчилгээг олгож 261 иргэнд газрын харилцаа улсын бүртгэлийн чиглэлээр цогц үйлчилгээг үзүүлсэн.	
2.2	Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд и-монгол цахим систем, бүртгэлийн цахим машинаар түргэн шуурхай авах нөхцлийг бүрдүүлж ажиллах, сурталчлах.	-	- Цахим систем болон машинаар үзүүлсэн үйлчилгээний тоо	0	2	Иргэд бүртгэлийн үйлчилгээг цахим орчинд авах боломжийг бүрдүүлж үйлчилгээний зааланд и-монгол цахим порталаар өөртөө үйлчлэх хэсэг, хэлтсийн байрны үүдний хэсэгт Бүртгэлийн цахим үйлчилгээ 24/7 булан гаргаж бүртгэлийн цахим машин байрлуулан иргэдэд 24 цагаар үйлчилгээ үзүүлж байна. Улсын бүртгэлийн цахим бүртгэлийн машинаар энэ онд 521 тоон гарын үсэг олгосон. “E-mongolia” цахим системээр 109 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх хүсэлт, гадаад паспорт 66, иргэний үнэмлэх 56 захиалж, E-business.mn хаягаар 571 шинэ нэрийн хүсэлт, цахим гэрчилгээ-2, шинээр үүсгэн байгуулах хуулийн этгээдийн хүсэлт-2 ирснийг тус тус хугацаанд нь шийдвэрлэсэн Хэрлэн , Бор-Өндөр сумдад КИОСК цахи машинаас 3860 гаруй иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн лавлагааг тус тус олгосон. Цахим төлбөрийн киоск машинаар бүртгэлийн үйлчилгээний төлбөр хураамж төлөх үйлчилгээг 936 иргэн	100

						үйлчилгээ авсан байна.		
2.3	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу эрхлэн хөтлөх.	-	Бүртгэсэн бүртгэлийн тоо;	17000	000	17	<ul style="list-style-type: none"> ➤ Иргэний улсын бүртгэлийн нийт 4885 бүртгэл бүртгэсэн. Үүнд: төрсний 518, гэрлэсний 125, гэрлэлт дуусгавар болсны 40, үрчилсний 12, овог, нэр өөрчилсний 20, эцэг тогтоосны 23, нас барсны 205, иргэний үнэмлэхний олголт 1396, гадаад паспортын 1630, шилжилт хөдөлгөөний бүртгэл 916 тус тус зохих журмын дагуу бүртгэж санд тусгаж баталгаажуулсан. Иргэний улсын бүртгэлтэй холбоотой 6804 лавлагаа олгосон байна. Нийт 11689 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна. ➤ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр: үйлчилгээ авах нийт 7113 мэдүүлэг хүлээн авч 6871 бүртгэл хийсэн. Үүнээс анхны бүртгэл 1331, өмчлөх эрх шилжих 1194, барьцааны гэрээ 2124, барьцааны гэрээ дуусгавар болгох 1840, бусад гэрээ 2, бүртгэлд өөрчлөлт оруулах 330, урьдчилсан тэмлэглэл 2, лавлагаа хуулбар 98 тус тус олгосон. ➤ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 1078 бүртгэлийг хүлээн авч бүртгэсэн байна. Үүнд: Шинээр байгуулсан хуулийн 	100

						этгээд-199, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт-124, оноосон нэрийн баталгаажуулалт-263, лавлагаа хуулбар-143, иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны хуудас олгосон болон хураан авсан тамга тэмдгийн бүртгэл-309 тус тус бүртгэсэн..	
Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.							
3.1	Улсын бүртгэлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангаж, программ хангамж ашиглалтад хяналт тавих.	-	Хяналт тавьсан тоо	4	4	<ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын мэдээллийн сан, сүлжээний аюулгүй байдал гадны халдлагаас хамгаалах ажлын хүрээнд УБЕГ-аас хамгаалалт бүхий ROUTER 2 ш, хэлтсээс 16 оролт бүхий SWITCH 1 ш, CONVERTER 3 хос ширхэгийг тус тус авч хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. ➤ Мөн улсын бүртгэгч нарын ашиглаж байгаа компьютер болон улсын бүртгэлийн программ хангамжид өөрчлөлт шинэчлэлийг давхардсан тоогоор 127 удаа тухай бүр холбогдон заавар зөвлөмж өгч, хяналт тавин ажилласан. ➤ УБЕГ-аас иргэн, эд хөрөнгийн цахим систмд шинэчлэл, хөгжүүлэлт хийж байгаатай холбоотой /update/ 5 удаа хийн ашиглалтад оруулан хяналт тавин ажиллаж байна. 	100

3.2	Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах.	-	Хуулийн хэрэгжилт, хувиар	100	100	<ul style="list-style-type: none"> ➤ Хэлтсийн төрийн захиргааны жинхэнэ албан хаагч 35 ажилтнаас 2023 оны “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг цаасан хэлбэрээр гаргуулан авч, www.meduuleg.iaac.mn сайтад бүртгүүлэн ХАСХОМ-ийн нэгдсэн тайланг хүргүүлсэн. Ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэлийг 3 албан хаагч гаргасаныг хянан баталгаажуулав. ➤ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу Хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусгавар болсон 1 албан хаагчийн ХАСХОМ-ийг хугацаанд нь мэдүүлж ажилласан. ➤ МУИХ сонгуульд итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах 96 албан хаагчдад төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийг танилцуулаж нууцын баталгааг гаргуулан авч ажилласан. 	
3.3	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг	-	-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	60	100	Хэлтсийн 2024 оны улсын бүртгэл хөтлөх үйл ажилллагаанд хяналт шалгалт хийх 3 зорилт 12 арга хэмжээтэй төлөвлөгөөг батлуулж	100

	хангах.					<p>хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Төлөвлөгөөний дагуу шалгалтаар Хэрлэн сумын 8 төрөл, шилжилт хөдөлгөөнийн нийт 650 бүртгэлд шалгалт хийж, 40 зөрчлийн тэмдэглэл үйлдэж улсын бүртгэгч нараар тухай бүр арилгах арга хэмжээ авч шийдвэрлэсэн.</p> <p>Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 1372, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 220, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 100, архивын үйл ажиллагаанд 240 хувийн хэрэгт үзлэг шалгалтыг хийж нийт 1932 бүртгэлд шалгалт хийж үүнээс 45 бүртгэлд зөрчлийг илрүүлж зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан .</p> <p>➤ Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.24.1, 15.24.2, 15.24.4-т заасны дагуу 124 иргэнд хялбаршуулсан журмаар торгох шийтгэл ногдуулж прокурорын газраар хянуулж ажилласан. Орон нутгийн төсвийн дансанд торгуулийн орлого 2,995,000 төгрөгийг төвлөрүүлсэн байна.</p>	
3.4		-	-Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд гарах зөрчлийг бууруулсан тоо;	31	40	Мэдээллийн сан цэгцлэх ажлын хүрээнд ИУБГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу нас барсны бүртгэл давхардсан 380 иргэний жагсаалт ирүүлснийг	100

	<p>Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх холбогдох арга хэмжээг авч ажиллах.</p>					<p>мэдээллийн санд болон архивын эх нотлох баримттай нягтлан тулгаж хүчингүй болгох 184 иргэний жагсаалт гаргаж хүргүүлсэн.</p> <p>Ижил овог, нэр, төрсөн он,сар, өдөртэй 116 иргэний мэдээллийг нэг бүрчлэн тулган шалгаж 16 иргэний төрсний бүртгэл давхар бүртгэлтэй байсныг Хяналтын улсын байцаагчийн 2024.02.16-ны өдрийн 655 дугаартай дүгнэлт гаргуулан холбогдох газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн.</p> <p>Хэрлэн сумын 2022, 2023 оны шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тулган шалгах ажлыг зохион байгуулж нийт 1389 бүртгэлийг цахим мэдээллийн санд нотлох баримтыг тулган шалгасан бөгөөд 26 зөрчлийг илрүүлж арилгах арга хэмжээг авч ажилласан.</p> <p>Иргэний үнэмлэхний зураг засварт 379 иргэний зургийг тулган шалгах ажлыг хийж, энэ тухай илтгэх хуудсыг ИУБГ-т хүргүүлсэн.</p> <p>Цахим хуудаст тавигдсэн сонгогчдын нэрийн жагсаалттай 355 иргэн танилцаж, 7 иргэн мэдээлэл зөрүүтэй талаар гаргасан гомдлыг хүлээн авч шалган, холбогдох иргэнд хугацаанд хэрхэн шийдвэрлэсэн талаархи хариуг өгч ажилласан.</p>	
--	--	--	--	--	--	---	--

3.5	Хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах.	-	-Хугацаандаа байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо -Тайлаганасан мэдээллийн мөнгөн дүн	158	159	<ul style="list-style-type: none"> ➤ Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2024 оны 04 сарын байдлаар нийт 55 мэдээллийг хуулийн хугацаанд цахим болон мэдээллийн самбарт байршуулсан. ➤ 2024 оны 04 дүгээр сарын байдлаар 435 920 400 төгрөгийн төсөв батлагдан ирснийг Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтаар батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай 414 936 160 төгрөгийн гүйцэтгэлтэйгээр зарцуулан нийт 20 984 240 төгрөгийг хэмнэж ажиллаад байна. ➤ Улсын их хурлын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 23 923 400 төгрөг дээд шатны төсвийн захирагчаас шилжин ирсэнийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. 	100
				1 200 000 000	1 200 000 000		
3.6	Аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх.	-	-Зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн хувь	0	80	<ul style="list-style-type: none"> ➤ 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн бусад холбогдох хууль журам зааврын дагуу гаргаж 2023.02.24 өдөр Хэнтий аймаг дахь аудитын газарт түүвэрт хамрагдаж зөрчилгүй илрээгүй. Зөвлөмж, акт албан шаардлага аваагүй болно. 	400

						➤ 2024 оны 1-р улирлын санхүүгийн тайланг хугацаанд нь УБЕГГазарт хүргүүлсэн. Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, үнэт цаасны тайланг тус тус 5 удаа санхүү төлөвлөлтийн хэлтэст тайлагнасан.		
Зорилт 4. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.								
4.1	МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, ажиллагааны гүйцэтгэлийн хувь	үйл	0	100	<p>МУИХСТХ-д заасан улсын бүртгэлийн байгууллагын чиг үүрэг, УБЕГ-ын сонгуулийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дараахь ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн хэлтсийн хэрэгжүүлэх 31 арга хэмжээ бүхий үйл ажиллагааны дэд төлөвлөгөө боловсруулж батлуулсан.</p> <p>Тус аймгийн 18 сумын ИТХТ-ийн сонгуулийн хэсэг байгуулсан тогтоолыг хүлээн авч улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд сонгуулийн хэсэг байгуулсан тухай тогтоол, сонгуулийн санал авах байрыг шивж оруулах ажлыг зохион байгуулж 2024.02.29-ний өдөр дуусгав.</p> <p>Тус аймгийн 18 сумын ИТХТ-ийн тогтоолыг нэгтгэн мэдээллийн санд шивж оруулахад тус аймгийн хэмжээнд нийт 89 сонгуулийн хэсэг байгуулагдаж санд бүртгэгдсэн.</p>	100

					<p>ELECTION.GASR.MN системд тогтоолыг цахимжуулж, тогтоол, санал авах байрны мэдээллийг шивж оруулах ажлыг иргэний улсын ахлах бүртгэгч хийж гүйцэтгэв.</p> <p>Мэдээллийн технологийн газраас сонгогчдод хэсэг оноох ажлыг зохион байгуулж тус аймгийн хэмжээнд нийт 51680 сонгогчдод хэсгийн дугаарыг үнэн зөв оноогоод байна. Улсын ахлах бүртгэгч хэсэг оноолтонд өдөр тутамд хяналт тавин ажиллаж байна. Масс хэсэг оноолтоос хойш шилжилт хөдөлгөөний бүртгэлээр үүссэн хэсэг оноогдоогүй 267 иргэнд нэмж хэсэг оноогоод байна.</p> <p>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйл, УБЕГ-ын даргын 2024.04.25-ны өдрийн А/61 дүгээр тушаалын дагуу иргэдийн засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлийг тус аймгийн 18 сум 89 багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2024.04.29-ны өдрөөс санал авах өдрийг дуустал хугацаанд түр зогсоосон.</p> <p>Хуульд заасны дагуу холбогдох 6 байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн сонгогчдын нэрийн жагсаалтад нэмэлт тэмдэглэгээ хийснийг нягтлан шалгахад эрх зүйн</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>чадамжгүй нь шүүхээр тогтоогдсон 36 сонгогч, хорих ангид ял эдэлж байгаа 204 сонгогч, Зэвсэгт хүчний цэргийн ангийн албан хаагч, ажилтан 69, цагдаагийн албан хаагч, ажилтан 74 сонгогчийн мэдээлэл үнэн зөв байна. Харин гадаадад 60 ба түүнээс дээш хоногоор зорчсон сонгогчийн хувьд 1744 иргэн нэмэлт тэмдэглэгээ хийгдсэн боловч 952 сонгогч нь байнга оршин суугаа хаягтаа одоо байгаа иргэд байв.</p> <p>Одоогийн байдлаар гадаадад 60-аас дээш хоногоор зорчсон гэх үндэслэлээр түр хасав нэмэлт тэмдэглэгээ тавигдсан 226 сонгогч мэдээллээ сэргээлгэхээр хүсэлт гаргаж тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p>Тагнуулын байгууллагын зөвшөөрлөөр 89 сонгуулийн хэсэгт ажиллах 90 итгэмжлэгдсэн ажилтантай ажиллах гэрээг байгуулж. 6 итгэмжлэгдсэн ажилтныг нөөцөд аваад байна. Итгэмжлэгдсэн ажилтнуудад эрх зүйн сургалтыг зохион байгуулсан.</p>	
4.2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, ажиллагааны гүйцэтгэлийн хувь үйл	0	100	III-IV улиралд хэрэгжих тул хугацаа болоогүй.	50
Зорилт 5.Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.							

5.1	Аймаг, сумын ИТХ, ЗДТГ болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах.	-	Хамтран ажиллах байгууллагын тоо	6	8	<p>Хэнтий аймгийн ЗДТГ-аас албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор Засаг дарга Ц.Чогсомжав Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад 8,0 сая төгрөгийн өртөг бүхий / dell latitude 3440 маркын нөтбүүк 1 ширхэг, dell суурин компьютер 1 ширхэг, hp laser 133 mfp принтер тус тус 1 ширхэгийг бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөх, бүртгэлийн үйлчилгээнд нэн шаардлагатай байгаа компьютер тоног төхөөрөмжийг шийдвэрлэж хүлээлгэн өгсөн.</p> <p>Хэнтий аймгийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Асуудлаас-Шийдэлд” арга хэмжээний дагуу хэлтсийн 1 албан хаагчийн амьдрах орчин нөхцлийг сайжруулж 2,0 төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Тайлангийн хугацаанд төрийн болон төрийн бус 8 байгууллага /Тагнуулын хэлтэс, ШШГГ, АЗДТГ, ГБХХГ, ГХБХБГ, ЦГ/-тай хамтран ажилласан. /Дэлгэрэнгүйг үйл ажиллагааны тайлангаас үзнэ үү/</p>	100
5.2	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг	ADB төсөл -	-Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг	3	6	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх авсан 13, хуулийн этгээдийн улсын	100

	үзүүлэх анхан шатны нэгжийн тоог нэмэгдүүлэх.		үзүүлж байгаа сумын тоо			бүртгэл хөтлөх эрх авсан 15 улсын бүртгэгч нарыг хуваарийн дагуу ажлын байрны дадлагажуулах сургалтыг зохион байгуулж, анхан шатны нэгжээс хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 45 үйлчилгээг үзүүлээд байна.	
Зорилт 6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.							
6.1	Авилгын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх ажлыг цахим болон бусад хэлбэрээр зохион байгуулах.	-	Олон нийтэд хүргэсэн цахим мэдээллийн тоо	0	5	Хэлтсийн цахим хуудаст тавигдсан авилгын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилсан 3 удаагийн зурган постер, мэдээ, мэдээллийг өөрийн цахим хуудаст түгээн тархааж, байршуулсан. Хэлтсийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх үүднээс Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 4:7:10 сургалтад тогтмол хамруулж байгаа бөгөөд тайлант хугацаанд 10 удаа оролцсон. Авлигын эсрэг НЭГДБЕ үндэсний хэмжээний нөлөөллийн аянд нэгдэж иргэдэд бүртгэлийн үйлчилгээг аль болох орон зай цаг хугацаанаас үл хамаарч түргэн шуурхай, чирэгдэлгүй цахимаар авах боломжтой талаар иргэдэд сурталчлах ажлыг ажлын байранд болон өдөрлөг, уулзалтад оролцох бүртээ таниулан тайлбарлаж байна./Дэлгэрэнгүйг хэлтсийн 2024 оны эхний хагас жилийн Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлангаас үзнэ үү/	100
			Зохион байгуулсан ажлын тоо	0	3		

.2	УБЕГ-ын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Хэлтсийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь	0	100	2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, даргын зөвлөлөөр хэлэлцэн баталсан. УБЕГ-ын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, iaac.mn цахим мэдээллийг ашиглан хооронд нь уялдуулан төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 11 арга хэмжээ, төлөвлөн боловсруулсан болно. Хэрэгжилтийг ханган 2024 оны эхний хагас жилийн тайланг хугацаанд нь t.narantsetseg@burtgel.gov.mn хүргүүлсэн.	100
Зорилт 7. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.							
7.1.	Хэлтсийн 2024 онд зохион байгуулах сургалт, мэдээллийн болон үндсэн ажлаас гадуур хийгдэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх.	-	-Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	80	100	Тус хэлтсийн 2024 онд хэрэгжүүлэх нэгдсэн сургалтын 4 зорилт 33 арга хэмжээтэй төлөвлөгөө, үндсэн ажлаас гадуур хийгдэх ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах 60 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 984 албан хаагчдыг хамруулаад байна. Иргэд олон нийт рүү чиглэсэн 25 удаагийн сургалт мэдээллийн арга хэмжээг зохин байгуулж 588 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан./дэлгэрэнгүйг	100

						сургалтын тайлангаас үзнэ үү./	
7.2.	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих.	-	-Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь;	100	100	<ul style="list-style-type: none"> ➤ “Хөдөлмөрийн дотоод журам”, “Байгууллагын үйлчилгээний стандарт”, “Үнэлгээний төхөөрөмж ашиглах журам”-ын хэрэгжилтийг өдөр тутамдаа мөрдлөг болгон ажиллаж байна. ➤ Тайлант хугацаанд улсын бүртгэгч бүр үйлчилгээ үзүүлсэн 4831 иргэнээс үнэлгээ авч, үүнд маш сайн-4092, сайн-724 дунд-12, муу-3 гэсэн үзүүлэлт байна. ➤ Мөн хэлтсийн албан хаагчдын цаг ашиглалтын бүртгэл, чөлөөний хуудасны бүртгэлийг хөтөлж, хоцрох тохиолдолд талон цоолох ажлыг хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар зөрчил /ажлын цаг ашиглалт, үүрэг даалгаварын биелэлт/ гаргасан албан хаагч байхгүй. ➤ Хэлтсийн ёс зүйн хорооны 2024 онд хийж хэрэгжүүлэх 8 заалт бүхий ажлын төлөвлөгөө болосруулж батлуулсан. Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр 1 дүгээр улиралд улсын бүртгэгч нарт албан бичгээр чиглэл, зөвлөмж 1 удаа хүргүүлсэн. Байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2022 оны тайланг, хавсралт 3 	100
			-Ёс зүйн арга хэмжээ авагдсан албан хаагчдын тоо;	3	0		

						<p>хүснэгтийн дагуу гарган АЗДТГ-т хүргүүлсэн.</p> <p>➤ Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан ёс зүйн хорооны талаарх 2 удаагийн уулзалт сургалтад хэлтсийн албан хаагчид 100 хувь хамрагдсан.</p>	
7.3	Өргөдөл, гомдол, албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд хянан, шуурхай шийдвэрлэх.	-	- Ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо	25	20	<p>Тайлангийн хугацаанд хэлтэст 20 өргөдөл, хүсэлт ирсний 16 нь иргэдээс, 4 хэлтсийн албан хаагчдаас, Ирүүлсэн 20 өргөдөл, хүсэлтийг холбогдох хууль журмын дагуу шуурхай 100 хувь шийдвэрлэсэн. Тайланг 2024.04.29-ны өдөр enkhzul.b@burtgel.gov.mn, tsolmon.s@burtgel.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.</p> <p>Иргэний улсын бүртгэлтэй холбоотой мэдээллийн санд нэмэлт өөрчлөлт оруулах 140 иргэний хүсэлтийг хүлээн авч холбогдох арга хэмжээ авч, мэдээллийн санд нөхөн бүртгэл, нэмэлт өөрчлөлтийг тусган ажилласан. 1 гомдлын дагуу гэрлэсний бүртгэлийн эх нотлох баримтад хяналт шалгалт хийж холбогдох хариу тайлбарыг гомдол гаргагчид хугацаанд нь хүргүүлсэн.</p>	100
7.4	Хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллага, эрх бүхий этгээдэд улсын бүртгэлийн мэдээ, мэдээлэл хүргүүлэх.	-	-Хүргүүлсэн мэдээний тоо	8	8	<p>➤ 2024 оны байдлаар түр оршин суух иргэдийн мэдээг багийн Засаг дарга нараас авч нэгтгэн ИУБГ-т хугацаанд нь 3 удаа хүргүүлсэн.</p> <p>➤ УБЕХ-ийн 12 дугаар зүйлийн</p>	100

						<p>12.5 дахь хэсэгт заасны дагуу хууль хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу албан бичгээр иргэний улсын бүртгэл 1038, хуулийн этгээдийн улсын бүртгэл 95, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 137 тус тус бүртгэлийн лавлагаа мэдээллийг олгосон байна.</p> <p>Улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тоон мэдээг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон нэгтгэж тухайн сарын 27-ны өдрийн дотор холбогдох чиглэлийн газруудад / ИУБГ-ын j.narantuya@burtgel.gov.mn, hurungu цахим хаягаар тус тус хугацаанд нь 5 удаа хугацааг хоцроолгүй хүргүүлсэн</p>	
7.5	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар хариуцлагын даатгалд хамрагдах.	-	Даатгалд хамрагдах улсын бүртгэгч нарын тоо	0	3	<p>УБЕГ-ын ЭХЭУБГазарт 2024.04.18-ний өдөр хуулийн этгээд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн хариуцлагын даатгалд хамрагдах 6 улсын бүртгэгчийн судалгааг гаргаж хүргүүлсэн байна.</p> <p>Хэрэгжилтийн хугацаа болоогүй.</p>	100
7.6	Шуурхай хурлаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг ханган хэрэгжилтийг тайлагнах /УБЕГ-ын даргын тушаал, шийдвэр, холбогдох	-	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	50	100	Тайлангийн хугацаанд УБЕГ-ын даргын 9 тушаал, УБЕГ-ын чиглэлийн газруудаас ирүүлсэн 23 чиглэл зөвлөмж, МУИХ-ын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны	100

чиглэлийн зөвлөмж, чиглэл/	газрын					ерөнхий төлөвлөгөө, УБЕГ-ын удирдах ажилтны шуурхай хурлаас өгсөн үүрэг 9 үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжилтийг ханган 8 удаа биелэлтийг гарган /1 үүрэг даалгаврын хугацаа болоогүй/. ochirbat@burtgel.gov.mn цахим хаягаар түстүс хүргүүлсэн.
-------------------------------	--------	--	--	--	--	---

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлсэн ажил	Гүйцэтгэл ийн хувь
1	2	3	4	5
“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
1.	Мэдлэг чадвараа дээшлүүлэх богино болон ахисан шатны сургалтад хамрагдах,	Мэргэшил дээшлүүлэх, ахисан шатны сургалтад хамрагдсан байна.	Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрх зүйн эчнээ ангид суралцаж 36 кредит цагийг судалж суралцсан.	100%
2.	Туршлага судлах арга хэмжээ зохион байгуулах	Төлөвлөгдсөн 2 ажил хэрэгжсэн байна.	Бор-Өндөр сумын улсын бүртгэгч нар Дархан, Баянмөнх сумдад, Батноров, Бэрх, Баян-Овоо, Норовлин сумдын улсын бүртгэгч нар хамтран Норовлин суманд нээлттэй өдөрлөг зохион байгуулж, энэ хүрээнд улсын бүртгэгч нар туршлага солилцож, сайн туршлагыг бие биеэсээ суралцав. Хэлтсийн байранд 7 улсын бүртгэгчид бүртгэлийн программд дадлагажих, туршлага судлуулах ажлыг зохион байгуулсан.	100%

			<p>Мөн хэлтсийн сургалтын төлөвлөгөөнд бүсчилж сургалт зохион байгуулах, туршлага солилцох ажлыг зохион байгуулах талаар санал оруулж тусгуулсан. Энэ ажлын хүрээнд 3 бүсийн улсын бүртгэгч нар хамтарсан сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх авсан сумын 12 улсын бүртгэгч ажлын байран дээр дадлагажих сургалтыг зохион байгуулаад байна.</p>	
	Дундаж оноо			

Тайлан хянасан:

Төсвийн төвлөрүүлэн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА...../Д.ДЭЛГЭРСАЙХАН/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....
(огноо)

Тайлан гаргасан:

Төсвийн Шууд захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА...../Б.ТӨРХҮҮ/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

(огноо)

.....